



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, 63 дугаар зүйлийн 63.1.2, 63.1.12, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 14 дүгээр зүйлийн 14.5, 14.8, 14.11, 14¹ дүгээр зүйлийн 14¹.5, 19 дүгээр зүйлийн 19.3, 19.12, 22 дугаар зүйлийн 22.5, 26 дугаар зүйлийн 26.2, 31 дүгээр зүйлийн 31.3, 39 дүгээр зүйлийн 39.3, 42 дугаар зүйлийн 42.2, 43 дугаар зүйлийн 43.3, 44 дүгээр зүйлийн 44.4, 55 дугаар зүйлийн 55.1.2, 55.1.9, 55.1.10, 55.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 198 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан журмын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг зохицуулалттай этгээдүүдэд үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛАХ ХУВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сан (цаашид “ХОС” гэх)-ийн үйл ажиллагаа, гэрээнд тавих шаардлагыг тогтоохтой холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэ журмаар хуулийн этгээдийн эрхтэй ХОС-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахгүй.

Хоёр. ХОС-г үүсгэн байгуулах бэлтгэл ажиллагаа

2.1. Үүсгэн байгуулагч нь ХОС-г үүсгэн байгуулах ажиллагааг эхлүүлэхээс өмнө дараах ажиллагааг гүйцэтгэсэн байна:

2.1.1. Үүсгэн байгуулагчийн товч танилцуулга, ХОС-г үүсгэн байгуулах гэрээ, шийдвэр, сангийн нэгж эрхийн танилцуулга, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 25.1.1-25.1.7, 25.1.9-25.1.11-д заасан журмын төсөл, хөрөнгө итгэмжлэн удирдах журмын болон татан буулгах ажиллагааны журмын төсөл болон бусад шаардлагатай баримт бичгийн төслүүдийг боловсруулах;

2.1.2. ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах, хадгалах үйлчилгээ авах болон ХОС-ийн нэгж эрхийг худалдахтай холбоотой гэрээний төслүүдийг боловсруулах;

2.1.3. зах зээлийн нөхцөл байдал болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах чиглэлээр холбогдох тооцоо судалгааг хийж гүйцэтгэсний үндсэн дээр үүсгэн байгуулах ХОС-ийн хөрөнгө оруулалтын салбар, чиглэлийг тодорхойлж, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах;

2.1.4. ХОС-г төлөөлөх, хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлэх кастодианыг сонгох.

2.2. ХОС-ийн үүсгэн байгуулах гэрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14¹.3-т зааснаас гадна дараах мэдээллийг тусгасан байна:

2.2.1. ХОС-ийн нэр, түүнийг тодорхойлсон, товчилсон ялгах тэмдэглэгээ;

2.2.2. ХОС-ийн зарласан болон гаргасан нэгж эрхийн тоо, нэрлэсэн үнэ;

2.2.3. ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлого, үйл ажиллагааны чиглэл;

2.2.4. ХОМК-ийн нэр, регистрийн дугаар;

2.2.5. кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар;

2.2.6. ХОС-ийн үйл ажиллагаа явуулах хугацаа буюу гэрээний хүчинтэй хугацаа;

2.2.7. ХОС-д оруулах хөрөнгө оруулалтыг санхүүгийн хэрэгслээр оруулж болох эсэх, оруулах бол тухайн санхүүгийн хэрэгслийг үнэлэх зарчим, аргачлал;

2.2.8. ХОМК-ийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа;

2.2.9. нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах харилцаа;

2.2.10.ХОС-ийн үйл ажиллагаа дуусгавар болгохтой холбоотой харилцаа;

2.2.11.бусад.

Гурав. ХОС-г үүсгэн байгуулах

3.1.Хороо ХОС-г үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэснээс хойш ажлын 10 өдрийн дотор үүсгэн байгуулагч нь санг үүсгэн байгуулах хурлаа хийж, энэ журмын 2.2-т заасан гэрээг баталснаар тухайн ХОС-г үүсгэн байгуулагдсанд тооцно.

3.2.ХОМК нь нэгж эрхийн танилцуулга, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан хөрөнгийг татан төвлөрүүлэх ажиллагааг үүсгэн байгуулагдсанаас хойш нэг сарын дотор гүйцэтгэнэ.

3.3.Энэ журмын 3.2-т заасны дагуу ХОС-ийн татан төвлөрүүлсэн хөрөнгийг кастодианы нэр дээрх тусгай дансанд байршуулна.

3.4.Энэ журмын 3.1, 3.2-т заасан хугацаанд үүсгэн байгуулах гэрээг баталж, хөрөнгийг татан төвлөрүүлээгүй тохиолдолд Хороо тухайн ХОС-ийн үүсгэн байгуулах баримт бичгийн бүртгэлийг хүчингүй болгоно.

3.5.Нэгж эрх худалдах, худалдан авах гэрээг хөрөнгө оруулагч ХОМК-тай байгуулснаар тухайн ХОС-ийн нэгж эрх эзэмшигч болно.

3.6. ХОС-г үүсгэн байгуулж, хөрөнгө татан төвлөрүүлсэн ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг ХОМК энэ журмын 3.2-т заасан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор дараах баримт бичгийн хамт Хороонд хүргүүлнэ:

3.6.1.нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл;

3.6.2.энэ журмын 2.1.1-2.1.3-д заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн баталгаажуулсан хуулбар;

3.6.3.Хороонд бүртгүүлсэн баримт бичигт өөрчлөлт орсон бол энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох өөрчлөлтийн үндэслэл.

Дөрөв. ХОС-ийн үйл ажиллагаа

4.1.ХОМК нь Хорооноос баталсан холбогдох журам, зааварт заасан шаардлагын дагуу сангийн цэвэр активын үнэлгээг гүйцэтгэх бөгөөд санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийг сангийн активт оруулж болно.

4.2.Хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодиан нь сангийн хөрөнгийг хадгалж, өөрийн хөрөнгөөс тусад нь бүртгэл хөтөлнө.

4.3.ХОМК нь ХОС-ийн хөрөнгийг үүсгэн байгуулах гэрээ, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, нэгж эрхийн танилцуулгад зааснаас өөр зориулалтаар ашиглаж, нэгж эрх эзэмшигч гишүүдийн оруулсан хөрөнгөд хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна.

4.4.Хуульд өөрөөр заагаагүй бол онцгой нөхцөл байдал болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан ХОС-ийн үйл ажиллагаанд үүсэх хохирлыг ХОМК хариуцахгүй.

4.5.ХОМК-ийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын бодлого, нэгж эрхийн танилцуулгын хүрээнд удирдаж буй эсэхэд хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодиан нь тухай бүр хяналт тавьж ажиллана.

4.6.ХОС-ийн актив нь үл хөдлөх хөрөнгөөр бүрдсэн ХОС-ийн хувьд шаардлагатай тохиолдолд активын багцад байгаа хөрөнгөө тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчин, эсхүл хөндлөнгийн

үнэлгээний байгууллагаар үнэлүүлж, цэвэр активын үнэлгээг гаргуулж болох бөгөөд тус этгээд нь ХОМК, кастодианы ажилтан, нэгдмэл сонирхолтой этгээдтэй аливаа сонирхлын зөрчил үүсгэлгүйгээр хөрөнгийн үнэлгээ хийх ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.7.ХОС-ийн үүсгэн байгуулах гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ талаарх мэдээллийг холбогдох баримт бичгийн хамт ажлын гурван өдрийн дотор Хороонд ирүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг нэгж эрх эзэмшигчдийн хурлаар баталсан байна.

4.8.ХОМК ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, нэгж эрхийн танилцуулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд холбогдох хүсэлтийг баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ. Хороо уг хүсэлт, холбогдох баримт бичгийг хууль тогтоомжид нийцсэн эсэхийг ажлын 10 өдрийн дотор хянаж, албан бичгээр хариу хүргүүлнэ.

4.9.ХОС-ийн гишүүний бүртгэлийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 22.1-д заасны дагуу хөтөлнө.

4.10.ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүн нь иргэн бол эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн нэгж эрхийн тоо хэмжээг, хуулийн этгээд бол оноосон нэр, тэдгээрийн регистрийн дугаар, түүний эзэмшлийн нэгж эрхийн тоо, хэмжээг тухайлсан бүртгэлд тусгана.

4.11.ХОС-ийн үүсгэн байгуулах гэрээ болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд өөрөөр заагаагүй бол ХОМК нь сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн бүртгэлийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

Тав. ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурал

5.1. Нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд үүсгэн байгуулах гэрээнд тусгагдсаны дагуу шаардлагатай тохиолдолд ХОМК-ийн хүсэлтээр, эсхүл нэгж эрх эзэмшигчдийн саналыг үндэслэн хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

- 5.1.1.ХОС-ийн үйл ажиллагааны тайлан;
- 5.1.2.ХОС-ийн хөрөнгийг удирдаж буй хөрөнгө оруулалтын зөвлөхийг өөрчлөх;
- 5.1.3.ХОС-ийн холбогдох баримт бичигт өөрчлөлт оруулах;
- 5.1.4.шимтгэл, хураамж, зардлуудад өөрчлөлт оруулах;
- 5.1.5.ХОС-ийн үйл ажиллагааг зогсоох, татан буулгах;
- 5.1.6.нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах;
- 5.1.7.гэрээнд тусгагдсан бусад.

5.2.ХОС-ийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг танхимаар, эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хуралд тухайн сангийн гишүүд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож болно.

5.3.ХОС-ийн нийт гаргасан нэгж эрхийн 50 ба түүнээс дээш хувийг эзэмшигч оролцсон тохиолдолд тухайн сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр болсонд тооцно.

Зургаа. ХОС-ийн мэдээллийн ил тод байдал

6.1.ХОМК нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон энэ журмаар тогтоосон мэдээлэл, тайлагналыг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь Хороо болон хөрөнгө оруулагчдад хүргэнэ.

6.2.ХОМК нь ХОС-ийн нэгж эрх эзэмшигчид дараах мэдээллийг тухай бүр мэдээлнэ:

6.2.1.нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл, танилцуулга;

6.2.2.ХОС-ийн нэгж эрхийн тав ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий этгээдийн талаарх мэдээлэл, түүний өмчлөл дэх нэгж эрхийн тоо, хувь хэмжээ;

6.2.3.ХОС-ийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, үүсгэн байгуулах гэрээ, журам, нэгж эрхийн танилцуулгад орсон өөрчлөлт, цэвэр активын үнэлгээний талаарх мэдээлэл;

6.2.4.Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд тухай бүр мэдээлэхээр заасан ХОС-ийн нэгж эрхтэй холбоотой мэдээлэл;

6.2.5.нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлын мэдээлэл;

6.2.6.ХОС-ийн үүсгэн байгуулах гэрээнд заасан бусад.

6.3.ХОМК нь ХОС-ийн жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг гаргах бөгөөд жилийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ.

6.4.Энэ журмын 6.3-т заасан жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгана:

6.4.1.ХОС-ийн бүтэц зохион байгуулалт, засаглал;

6.4.2.ХОС-ийн хөрөнгө оруулалтын бодлого, стратеги, эрсдэл, эрсдэлийн удирдлага;

6.4.3.ХОС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүн;

6.4.4.ХОС-ийн активын багц, цэвэр активын үнэлгээ, нэгж эрхийн үнэ;

6.4.5.нэгж эрх эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нөлөө үзүүлэхүйц ач холбогдол бүхий мэдээлэл;

6.4.6.ХОС-д холбогдох үйлчилгээг үзүүлж буй ХОМК, кастодианы талаарх ерөнхий танилцуулга, тэдгээрийн тухайн ХОС-тай холбогдуулан авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаарх тайлан;

6.4.7.ХОС-ийн үйл ажиллагааны ашигт ажиллагаа, орлого, зардлын харьцаа үзүүлэлтүүд;

6.4.8.Хорооноос баталсан журам болон үүсгэн байгуулах гэрээнд заасан бусад.

6.5.ХОС нь энэ журамд заасан мэдээллийг нэгж эрх эзэмшигчид хүргэхтэй холбоотой зохицуулалтыг холбогдох журамдаа тусгаж, үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллана.

6.6.ХОС болон ХОС-д үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаатай холбоотойгоор аливаа сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд Хороонд тухай бүр мэдээлж ажиллана.

Долоо. ХОС-г татан буулгах ажиллагаа

7.1.ХОС-г Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу сайн дурын үндсэн дээр татан буулгаж болох бөгөөд дараах тохиолдолд санг албадан татан буулгана:

7.1.1.шүүх болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр татан буулгах шийдвэр гаргасан;

7.1.2.Хорооноос хөрөнгө оруулагчдын эрх ашиг ноцтой зөрчигдөх нөхцөл үүссэн гэж үзсэн, газар дээрх шалгалтаар татан буулгах нөхцөл бүрдсэн.

7.2.Энэ журмын 7.1-д заасны дагуу ХОС-г сайн дурын үндсэн дээр татан буулгах тохиолдолд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг үзүүлж буй ХОМК нь дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

7.2.1.ХОС-ийн нэгж эрхийн эзэмшигч гишүүдийн хурлаас өмнө тухайн ХОС-г татан буулгах ажиллагааны төлөвлөгөөний талаарх мэдээллийг хүргэх бөгөөд уг төлөвлөгөөнд санг татан буулгах шалтгаан, татан буулгахад гарах зардал, сангийн цэвэр активын үнэлгээ, өр төлбөрийг төлсний дараа үлдэх хөрөнгийг хөрөнгө оруулагчид хуваарилах талаар тусгах;

7.2.2.нэгж эрх эзэмшигч гишүүдийн хурлаар татан буулгах ажиллагааны төлөвлөгөө, шийдвэрийн төслийг танилцуулах;

7.2.3.ХОС-г татан буулгах ажиллагааг гүйцэтгэх явцад гүйцэтгэлийн мэдээллийг нэгж эрх эзэмшигчид тухай бүр хүргэж, ХОС-ийн цэвэр активын үнэлгээг зах зээлийн үнэлгээнд тулгуурлан бодитойгоор үнэлж, оролцогч талуудтай сонирхлын зөрчил үүсгэхээс сэргийлж ажиллах.

7.3.ХОМК нь ХОС-г татан буулгахтай холбоотой баримт бичгийг уг ажиллагаа хийгдэж дууссан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд ирүүлэх бөгөөд Хороо татан буулгах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхийг ажлын 15 өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

~o0o~